

## Өмнөх үг

Монгол улс нь феодалын хоцрогдмол нийгмээс хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон болох түүхэн хөгжлийг туулсан бөгөөд 1990 оноос зах зээлийн эдийн засагтай ардчилсан нийгэмд шилжих үйл явц үргэлжилж байна. Өнөөдөр нийгэм эдийн засгийн өргөн хүрээг хамарсан өөрчлөлтөөс үүдэн Монгол орны эдийн засаг, хүн ам зүйн төлөв байдлыг судлах зайлшгүй шаардлага тавигдаж байна.

Монгол орны хөгжлийн үйл явцад хүн амын асуудал чухал гэдэгт засгийн газар байнга анхаарлаа хандуулсаар ирсэн билээ. Монголд мэдээллийн систем харьцангуй сайн хөгжсөн хэдий ч хүн ам зүйн мэдээллийг ашиглан төрийн аливаа бодлого боловсруулах түвшинд хүртэл шинжилгээ, судалгаа хийх явдал хангалттай бус байна.

НҮБ-ын Хүн Амын Сангийн тусламжтайгаар 1992 онд МУИС-ийн дэргэд байгуулагдсан Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны Төв нь хүн ам зүйн сургалт явуулахаас гадна судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлд онцгой анхаарал тавин ажиллаж байна. Харамсалтай нь өнөөг хүртэл Монголын хүн ам зүй судлаачдад өөрсдийн бүтээлээ нийтлүүлэх судалгааны тогтмол сэтгүүл хараахан байсангүй. ХАЗССТ-өөс энэ төрлийн тогтмол хэвлэл бий болгож байгаа бөгөөд "Монголын хүн ам зүйн сэтгүүл"-ийн гурав дахь дугаарыг та бүхний гарт хүргэж байна. Өөрсдийн санаачилгаар шаргуу ажиллаж буй ХАЗССТ-ийн багш нар, судлаачдад болон энэхүү сэтгүүлд бүтээлээ ирүүлж буй хүмүүст талархаж байгаагаа илэрхийлье.

Энэ сэтгүүл нь судлаачид, бодлого боловсруулагчид болон бусад сонирхсон хүмүүсийн таашаалд нийцнэ гэдэгт найдаж байна. Мөн түүнчлэн энэ сэтгүүлд нийтлэгдсэн өгүүллүүд нь гадаадын уншигчдад Монголын хүн амын талаарх мэдээлэл өгөхөд тус дөхөм болох болов уу.

( Профессор Ц. Ганцог )  
Ректор  
Монгол Улсын Их Сургууль